



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ  
ДЭЛҮҮН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 16 өдөр

Дугаар А/1409


Рашаант

Газар эзэмшүүлэх эрхийн цахим дуудлага  
худалдаа дахин зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ын 10.1.5, 10.2 дахь хэсэг, Барилга хот байгуулалтын сайдын 2018 оны 208 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааны анхны үнийг тодорхойлох аргачлал, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн “2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай” 58 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дахин дуудлага худалдаагаар эзэмшүүлэх 7 нэгж талбарын газрын хэмжээ, зориулалт, анхны үнэ, дэнчингийн хэмжээг хавсралтаар баталсугай.
2. Газар эзэмшүүлэх эрхийн дахин дуудлага худалдааг 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдөр цахим хэлбэрээр зохион байгуулсугай.
3. Газар эзэмшүүлэх эрхийн дахин дуудлага худалдааг захирамж гарсан өдрөөс эхлэн 14-өөс доошгүй хоног олон нийтэд ил тод зарлан, зохих журмын дагуу товлосон хугацаанд зохион байгуулахыг сумын газрын даамал /Б.Берденбек/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Б.СЕРИКБОЛ